



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 681

танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯННУУР
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баяннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Л.Одончимэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021372

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Л.Одончимэг Баяннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Л.Одончимэгийн мөрийн хөтөлбөр (.....³хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Л.Одончимэгт

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**БУЛГАН АЙМГИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЛХАГВА ОВОГТОЙ
ОДОНЧИМЭГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Булган аймгийн ИТХ-ын сонгуульд Баяннуур сумаас нэр дэвшигч Лхагва овогтой Одончимэг би энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа "Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", Монгол улсын "Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр", Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050" "Шинэ сэргэлтийн бодлого" "Булган аймгийн хөгжлийн цогц бодлого" Тус сумын дэд бүтэц, зам харилцаа газар зүйн байршил, хүн амын бүтэц онцлог зэргийг харгалзан орон нутгийн байгууллага иргэд, олон нийтийн саналд үндэслэн боловсруулж, тодорхойллоо.

Мөрийн хөтөлбөр нь хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, ногоон хөгжлийн бодлого, засаглалын бодлого, бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн 4 бүлгийн 28 зорилтоос бүрдэж байна.

Нэг. Нийгмийн бодлогын хүрээнд

1.1. Эрүүл мэнд

1.1.1 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, Халдварт өвчний тандалт сэргийлэлтийг сайжруулж, эрт илрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хүний хөгжлийг хангах, эрүүл мэндийг хамгаалах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, соён гэгээрүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулна.

1.1.2. Эрүүл мэндийн ажилтаны чадавхыг сайжруулах давтан сургах мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах боловсруулна.

1.1.3. Хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох зан үйлийг төлөвшүүлэх бодлого санаачлан боловсруулна.

1.2. Боловсрол

1.2.1 Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахуйд суралцах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах бодлого боловсруулна.

1.2.2. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломж, тэдний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулна.

1.2.3. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, "Хүүхдэд ээлтэй" сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх бодлого боловсруулна.

1.3.Биеийн тамир

1.3.1.Хүн амыг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл дадал хэвшилд сургах орчин нөхцөлийг сайжруулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлж ,биеийн тамир спорт эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсыг сурталчилан таниулах хөтөлбөр боловсруулна.

1.3.2. Үндэсний спорт болон уламжлалт тоглоом наадгай, спортуудыг хөгжүүлэх, тамирчдын амжилтыг ахиулах биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулна

1.4.Соёл урлаг

1.4.1. Орон нутгийн соёлын байгууллагууд, иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилан соёлын өвийн судалгааг хийж, хамгаалалтад авах бодлого боловсруулна.

1.4.2. Соёл урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлтгэж, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого боловсруулна.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж хамгаалал

2.1.1.Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр боловсруулна.

2.1.2.Цахим Монгол' хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр , нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй болгох бодлого боловсруулна.

2.1.3.гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн. бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах хөтөлбөр боловсруулна.

2.1.4.Нийгмийн зорилтод бүлгүүдийн хуулийн дагуу нийгмийн халамж тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээнүүдэд бүрэн хамруулан хөнгөн шуурхай үйлчилэх дэд хөтөлбөр боловсруулна.

2.1.5. Амьдралын түвшин доогуур орлоготой болон, өрхийн орлого бага иргэдэд чиглэсэн нийгмийн халамж хамгаалалыг сайжруулах бодлого боловсруулна.

2.1.6.Өндөр настны эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого боловсруулна.

Гурав .Эдийн засаг, Хөдөө аж ахуй

3.1.1. “Шинэ хөдөө-Булган” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах хөтөлбөр боловсруулна.

3.1.2. Малын гоц халдварт өвчний мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулах, бэлчээрийн даац багтаамжид нийцүүлж малчдыг сэлгэн нүүлгэх менежментийг боловсруулан хадлан, бэлчээрийг нөхөн сэргээх бодлого боловсруулна.

3.1.3. Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүнсний ногоо, нарийн ногооны нэр төрлийг олшруулж, өвлийн болон нарлаг хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулна.

3.1.4. Хадлангийн талбайн ашиглах, сэргээх га-аас авах ургацыг нэмэгдүүлэх, өвс тэжээлийн хадгалалт хамгаалалт борлуулалт, хадланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого боловсруулна.

3.1.5. Малын бэлчээрийн даац хэтрэлт, нутгийн иргэдийн өвөлжөө хаваржаа бэлчээрийг хамгаалах, малын тоо толгойн зохист харьцааг барих бодлого боловсруулна.

3.1.6. Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулна.

3.1.7. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжих орон нутагтаа үйлдвэрлэл эрхлэх гарааны бизнесийг дэмжих бодлого хөтөлбөр боловсруулна.

Дөрөв. Байгаль орчин аялал жуулчлал

6317144798
ГЮА0048 3190269

4.1.1. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх бодлого боловсруулна.

4.1.2. Ус, рашааны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, хэмнэх, хуримтлуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулна.

4.1.3. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, орчны бохирдол доройтлыг бууруулж, шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх бодлого боловсруулна.

4.1.4. Цөлжилттэй тэмцэх орон нутгийг ойжуулах чиглэлээр модны төрөл зүйлийг нэмэгдүүлэх, услалтын системийг боловсронгуй болгох, модны амьдралтын хувийг нэмэгдүүлэх, гол нуур, мод бут сөөгийг хамгаалах, хортон мэрэгчтэй тэмцэх, усжуулах, байгалийг аясаараа нөхөн сэргэх, ундны ус, рашаан, булгийн эх, ундарга, орчныг хамгаалах чиглэлээр байгаль орчны бодлого боловсруулна.

4.1.5. Байгаль, түүх, соёлын өвийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулна.